



ROYAL MOTOR AUTO СЭЙЛС ХХК

**ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар баг
Төр захиргааны II байр Утас: 77553579
Цахим шуудан: tuvprocurement@tov.gov.mn

2024.03.11 № 01/26
танай _____ -ны № _____ -т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

ТӨАХААГ/20240102099, Сум, төсөвт байгууллагуудын автомашины парк шинэчлэлд орон нутгийн оролцоо (ХААГазар) гүйцэтгэгч сонгон шалгаруулалтад ирүүлсэн танай тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26, 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлэхэд дараах шаардлагыг хангахгүй байна. Үүнд:

ТӨХ, ТШЗ-н заалт	Захиалагчийн тавьсан шаардлага	Тендерт оролцогчийн санал	Шалгараагүй тухай тайлбар
ТШЗ Error! Reference source not found.	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг: “Шаардана.” Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ	Ирүүлсэн	Тендер нээсэн өдрийн байдлаар татварын ерөнхий газрын лавлагааг системээр татан үзэхэд тус оролцогч нь 2,406,633.75 төгрөгийн дутуу үлдэгдэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т заасны дагуу ерөнхий нөхцөл хангахгүй байна

Иймд үнэлгээний хорооны дүгнэлтээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т заасны ерөнхий нөхцөл хангахгүй байх тул танай тендерийн хянан үзэх боломжгүйг мэдэгдэж байна.

Захиалагчийн энэхүү шийдвэрт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйл 55.1 дэх хэсэгт зааснаар гомдол гаргах эрхтэйг уламжилъя.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАНХУЯГ



12402039